

**НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ИЛЭРСЭН  
ЗӨРЧЛИЙН ДАГУУ АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГТГЭЛ**

2018 оны 05 дугаар сарын 30 ны өдөр

Д/Д	Байгууллагын нэр	Сорил хийсэн дансны нэр	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /мян.төг/	Биелэлт
1	Нийслэлийн түргэн тусламжийн төв	Цалин	Ээлжийн амралтын мөнгийг цалинтай давхардуулан олгосон	4,986.1	2018.05.17 нд ажилчдаас суутган, зөрүүг ондоо багтаан суутгахаар авлага үүсгэн бүрэн барагдуулсан. /Ээлжийн амралтын эдлэх хоногоос илүү буюу дутуу амарсан ажилчдын жагсаалтыг гарган хүний нөөц, нэгж албадын дарга нартай хамтран уг ажилчдыг нөхөж амраах хугацааг сар тутамд тохирч баримтжуулж байна. Үүнд: Эмнэлэг үйлчилгээнд ээлжиндээ дуудлаганд гарах эмч, жолооч дутагдсанаас 1-4 сарын байдлаар 4 хүн нийтдээ 13 хоног амралтаа дутуу эдэлж цалинг гүйцэтгэлээр олгосон тул уг ажилчдыг эхний хагас жилд багтаан нөхөж амруулахаар хүний нөөц, салбарын дарга нарт мэдэгдсэн. Мөн 2 удирдах ажилтан хагас жилийн тайлан, мэдээг гаргах ажлын шаардлагаар ажиллаж байгаа тул дутуу эдэлсэн амралтын хоногийг 6- 7 саруудад амраахаар удирдлагатай хэлэлцсэн. Уг хяналтын ажлуудыг тухайн жил дуустал хугацаанд эргэн хянаж тайлагнах зэрэг ажлуудыг тасралтгүй явуулах болно/
2	Нийслэлийн түргэн тусламжийн төв	Шатахуун	Албан бус хэрэгцээнд шатахуун, илүү цагийн хөлс олгосон	616.1	2018.05.17 нд ажилтанаас суутган, зөрүүг ондоо багтаан суутгахаар авлага үүсгэн бүрэн барагдуулсан. /Техникийн албаны гаргасан ээлжийн ажилчдын хуваарийн дагуу замын хуудас, дагалдах хуудасыг үндэслэн олгож, хянаж сар бүр хэвшсэн. Уг гүйцэтгэлд давхар хяналт хийгдэж байна. Цаашид GPS систем автомашин бүрд суугдах тул хяналтыг газар дээр шууд хянаж тооцох боломжтой./
3	Нийслэлийн түргэн тусламжийн төв	Эм	Эмийн тайлангаас илүү зарлагдсан	110.0	2018.05.17 нд ажилтанаас суутган, зөрүүг ондоо багтаан суутгахаар авлага үүсгэн бүрэн барагдуулсан. /Аудитаар илэрсэн зөрчил нь эмийн нэр төрлийг захиалгын хуудсанд худалдааны нэршлээр (Сальбутамол эмийн нэрийг вентолин гэдэг нэрээр) 6 сарын тайланд бичигдсэнийг шалгалтанд хамрагдсан саруудад ажиллаж байсан тооцооны нягтлан солигдсоноос дараагийн ажил хүлээж авсан нягтлан аудитын хяналтын явцад мэдэлгүй өнгөрөөсөн учраас акт тавигдсан. Иймд өмнөх онд манай байгууллагад туршилтаар хэрэгжүүлж эхлүүлсэн эмийн сангийн программ хангамжийг эмийн агуулах болон салбар төвүүдэд тус бүр шинээр суулгуулсанаар энэ оноос эхлэн ашиглаж эхлэх болсон тул эмийн нэршлийг нэг төрөл нэрээр тогтоосон. Уг зөрчилд дурьдагдсан захиалгын хуудас программ хангамжаас бүртгэгдэн хэвлэгдэн бүртгэгдэх учраас зөрчил давтагдахгүй гэж үзэж байна/
<b>Нийт дүн</b>				<b>5,712.2</b>	<b>2018.05.17 нд НИЙТ 5712.2 мянган төгрөгийг төлж барагдуулав.</b>

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН  
АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН ДАГУУ АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГТГЭЛ

2018 оны 05 дугаар сарын 30 ны өдөр

Д/Д	Байгууллагын нэр	Сорил хийсэн дансны нэр	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /мян.төг/	Биелэлт
1	Нийслэлийн түргэн тусламжийн төв	Цалин	Ажилчдын хурлаар хэлэлцүүлээгүй, үндэслэлгүй, үр дүн давхардуулан 0.5-1 сарын цалингийн урамшуулал олгосон	18,698.0	Улирал бүрт албадын дарга нарын ажил дүгнэлтийн хурал хуралдуулж хурлын тэмдэглэлийг үндэслэн захирлын тушаал шийдвэрээр үр дүнгийн улирлын урамшуулалыг улиралдаа 1 удаа олгож байна.
		Цалин	Нэг удаагийн тэтгэмжээс НДШ-ыг хассан дүнгээс тооцолгүй шууд татварыг 10 хувиар ноогдуулсан	1,030.0	Цаашид хуулийн дагуу суутгал, шимтгэлийг тооцон ажиллаж хэвшсэн.
<b>Нийт дүн</b>				<b>19,728.0</b>	